

ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын сар тутмын сонин 2017 оны 12 сарын дугаар

Тэргүүн Мэдээ

“Төсөв, нийгэм, эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээл”-ийн хэлэлцээрт гарын үсэг зурж Монгол Улсын эдийн засаг, төсвийн санхүүг сэргээн босгоход дэмжлэг үзүүлэх болов.



Зээлийн гэрээнд гарын үсэг зурах ёслол (Зүүн гараас: ЖАЙКА-ийн Тэргүүн Дэд ерөнхийлөгч Кошикава Казухико, баруун гараас: Сангийн сайд Ч.Хүрэлбаатар)

Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (JICA) 12 сарын 5-ны өдөр Улаанбаатар хотноо Монгол улсын засгийн газартай “Төсөв, нийгэм болон эдийн засгийн шинэчлэлийн хөгжлийн бодлогын зээлийн санхүүжилтийн төсөл”-ийн хүрээнд олгох 32 тэрбум иений зээлийн санхүүжилтийн хэлэлцээрт (Loan Agreement: L/A) гарын үсэг зурав.

Монгол улсын Засгийн газрын төсвийн алдагдал 2016 онд ДНБ-ний 17 хувьд хүрснээс гадна, 2011 онд ДНБ-ний 33 хувьтай тэнцэж байсан засгийн газрын өр 2016 онд 88 хувь болж нэмэгдэн эдийн засаг, төсвийн санхүүг шинэчлэх асуудал нэн тэргүүний зорилт болоод байна.

Уг нөхцөл байдалтай холбогдуулан 2017 онд ОУВС, Дэлхийн Банк, АХБ-ын голлох оролцоотойгоор нийт дүн 5.65 тэрбум ам.долларын олон улсын дэмжлэгийн багцыг бүрдүүлээд байна. Энэхүү төсөл нь уг олон улсын дэмжлэгийн хүрээнд монгол улсын эдийн засаг, төсвийн санхүүг сэргээн босгох үүднээс тус улсын засгийн газраас макро эдийн засгийн тогтвортой удирдлагыг хангах, нийгмийн эмзэг бүлэгт үзүүлэх дэмжлэгийг эрчимжүүлэх, эдийн засгийн өсөлтийг дэмжих гэсэн 3 чиглэлээр хэрэгжүүлж буй шинэчлэлийн арга хэмжээг дэмжих юм.

Улс төр, эдийн засгийн чиг хандлага

2018 оны 1 дүгээр сараас хүн амын орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдэнэ.

2018 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүн амын орлогын албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ нэмэгдэх болоод байгаа. Хүн амын орлогын шаталсан татварын тогтолцоо нэвтэрсэнээр орлогын хэмжээнээс хамааран дээд тал нь 25%-ийн татвар ногдохоос гадна архи, тамхины онцгой албан татвар 10%, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээ үе шаттайгаар нэмэгдэх (2018 онд 1 %) төлөвтэй байна. Эдгээр нь Засгийн Газрын орлогыг нэмэгдүүлэх арга хэмжээний нэг, ОУВС-ийн дэмжлэгийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэг нөхцөл болж байгаа боловч иргэдэд учрах дарамтыг нэмэгдүүлэх тул Монгол Улсын эдийн засагт ямар нөлөө үзүүлэх нь анхаарал татаж байна.

Төслийн хэрэгжилт

“Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны анхдугаар хурал болов.



ХЗХ-ын хурал дээр барилгын талбайн байдлыг тайлбарлаж буй мэргэжилтэн Кишикава Шожиро.

12 дугаар сарын 14-нд “Барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл”-ийн Хамтарсан зохицуулах хорооны (JCC) анхдугаар хурал болов. 2017 оны 6 дугаар сараас эхлэн 4 жилийн хугацаатай хэрэгжих энэхүү төслийг Монголын талаас БХБЯ болон МХЕГ, БХТ хариуцан хэрэгжүүлж байгаа бөгөөд барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын бодлого боловсруулах, сургалтын хөтөлбөр, гарын авлагыг боловсронгуй болгох, загвар төслийн талбайд жишиг сургалт явуулах замаар төрийн захиргааны ажилтнуудын барилгын салбарын хөдөлмөрийн аюулгүй байдлын хяналтын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Энэ удаагийн Хамтарсан зохицуулах хорооны хурлаар төсөл хэрэгжиж эхлэснээс хойшхи хагас жилийн хугацаанд барилгын аюулгүй байдалтай холбоотой хууль тогтоомжийн судалгаа, барилгын талбар дахь судалгаа хийгдэж, дотоодод болон Японд сургалт зохион байгуулах зэргээр төслийн үйл ажиллагаа ерөнхийдөө төлөвлөгөөний дагуу явагдаж ирснийг онцлон, холбогдох талууд 2018 оны төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөг нягталж, Япон, Монгол хоёр тал уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлд хамтран ажиллахаа харилцан бататгав.

“Уул уурхайн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд судлаачдын чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ салбарын судалгааны агуулгыг танилцуулав.



Мураками професорын лекц

ТХА “Уул уурхайн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд Монгол улсын эрдэс баялгийн тогтвортой ашиглалтыг хангах үүднээс бодлогын зохистой төлөвлөлтөд шаардлагатай мэдээллийн анализ болон судалгаа шинжилгээний ажлын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлж байна. Энэхүү төслийн хүрээнд 12 сарын 12-ны өдөр Японы мэргэжилтэн Токиогийн их сургуулийн профессор Мураками Жүн МУИС дээр Монголын эрдэмтэн судлаачдад “Материалын урсгал · хөрөнгийн шинжилгээ, нөөцийн эдийн засаг” сэдвээр лекц уншив. Уг лекц нь уламжлалт эрдэм шинжилгээний ажлын хүрээнд даван, шинэ салбарт судалгаа хийх асуудлыг дэвшүүлснээрээ онцлог бөгөөд эдийн засгаар мэргэшиж буй судлаачид шимтэн сонсож байлаа. Энэхүү төслийн хүрээнд 2019 он хүртэл судалгаа, шинжилгээний ажилтай холбоотой дэмжлэг үзүүлэх юм.

Гал унтраах тоног төхөөрөмж болон ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн дараах хамтын ажиллагаа(Follow-up)



Хүлээлгэн өгөх ёслол(Өмнө нь байгаа хайрцаг нь сэлбэг хэрэгслийн нэг хэсэг)

2003 онд буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжсэн “Гал унтраах тоног төхөөрөмж болон ашиглалт, засвар үйлчилгээг сайжруулах төсөл”-өөр нийлүүлсэн 17 гал унтраах машиныг НОБГ өнөөг хүртэл ашиглаж байгаа билээ. Эдгээр машины оригиналь сэлбэг хэрэгслийг монголд худалдан авах боломжгүйгээс гуравдагч орны сэлбэгийг орлуулан ашиглаж ирсэн нь техникийн ашиглалтын хугацаанд сөргөөр нөлөөлж ирсэн. Энэхүү нөхцөл байдалд Японы ОУХАБ Follow-up буюу “Төслийн дараах хамтын ажиллагаа”-г хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний үр дүнд 12 сарын 13-ны өдөр 251 төрлийн нийт 837 ширхэг сэлбэг хэрэгслийг ОБЕГ-т хүлээлгэн өглөө. Сэлбэг хэрэгсэл хүлээлгэн өгөх ёслолын ажиллагаанд үеэр ОБЕГ-ын дарга Т.Бадрал болон бусад албаны хүмүүс оролцож сэлбэг хэрэгсэл нийлүүлж, инженер илгээн засвар үйлчилгээний зааварчлага өгсөнөөр цаашид урт хугацаанд үр бүтээлтэй ашиглах боломжтой боллоо хэмээн Япон талд талархал илэрхийлэв.

“Шударга өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл”-ийн мэргэжилтэн Курода ШӨХТГ-ын даргын шагнал хүртэв.



ШӨХТГ-ын даргын шагнал хүртэж буй мэргэжилтэн Курода.

11 сарын 17-ны өдөр ТХА “Шударга өрсөлдөөний орчныг сайжруулах төсөл” –ийн мэргэжилтэн Курода болон төслийн туслахаар ажиллаж байсан Намжилмаа нарыг Монгол Улс дахь зах зээлийн шударга өрсөлдөөний орчныг сайжруулахад оруулсан хувь нэмрийг нь үнэлэн төслийн Монгол талын хэрэгжүүлэгч байгууллага болох ШӨХТГ-ын даргын шагналаар шагнав. Шагнал хүртсэн мэргэжилтэн Куродагийн сэтгэгдэл: “Ёслолын ажиллагаа болсон өдрийн өглөө нь шагнал авах болсоноо мэдээд сандарсан. Энэ хүндтэй шагнал авсандаа нэр төрийн хэрэг хэмээн бодож байна. Энэхүү шагнал нь надад төдийгүй өнөө хүртэл төслийг бүх талаар дэмжин ажиллаж ирсэн Японы Шударга Худалдааны Хорооны хамт олон, ЖАЙКА-ийн Төв болон Монгол дахь төлөөлөгчийн газрын хамт олон болон төслийн ажилтнуудад олгогдсон шагнал гэж бодож байна. Цаашид төслийг амжилттай хэрэгжүүлэн Монгол Улсын хөгжилд хувь нэмэр оруулахын төлөө хичээн зүтгэх болно.”

Мэргэжилтэн Үмэмура Монгол улсын ХААИС-ийн хүндэт профессор болов.



Мэргэжилтэн Үмэмура (голд нь) болон төслийн багийн гишүүд.

12-р сарын 3-ны өдөр Монгол улсын мал эмнэлгийн боловсролын 75 жилийн ойн ёслолын арга хэмжээний үеэр ТХА “Мал эмнэлэг, МАА-н салбарын хүний нөөцийн хөгжлийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн мэргэжилтэн Үмэмура Такашид ХААИС-ын “Хүндэт профессор” цол олгов. Одоо хэрэгжиж буй уг төслийн хүрээнд мал эмнэлэг, МАА-ын салбарын мэргэжилтнүүдийн чадавхийг дээшлүүлэхийн тулд Мал эмнэлгийн сургуулийн сургалтын хөтөлбөр болон сургалтын тогтолцоог сайжруулах, багш, малын эмч нарын чадавхийг дээшлүүлэх зорилт тавин ажиллаж байна. Үмэмура мэргэжилтэн нь энэхүү төслийн бэлтгэл үе шатнаас оролцон, 2014 оноос өнөөг хүртэл төслийн зөвлөх, мал эмнэлэг зүйн эмгэг судлаач мэргэжилтнээр ажиллаж ирсэн бөгөөд Монгол улсын мал эмнэлгийн салбарт олон жилийн турш оруулсан хувь нэмрийнхээ төлөө уг хүндэт өргөмжлөлийг хүртсэн байна.

Бусад үйл ажиллагаа

- Дэлхийн халуун өнцөг нийтлэл: Койчи Икэда (ЖАЙКА-ийн ажилтан) “Нүүдэлчдийн амьдралаар дамжуулан мэдэж авсан Монгол хүний ахуй амьдралтай салшгүй холбоотой таван хошуу мал болон нүүдэлчдийн уялдаа холбоо ” → линк [энд дар.](#)

Сайн дурын үйл ажиллагааны танилцуулга (“Дэй Кэа” буюу өдрийн сувилахуйн үйлчилгээ Дархан-Уул аймагт)



Эмнэлэг дээр өдөр тутмын сувилалын зааварчлага өгч буй Фужикава сайн дурын гишүүн.

Дархан-Уул аймгийн өрхийн болон сумын эмнэлэгүүдэд 2016 оны 9 сараас 2017 оны 8 сар хүртэл ЖАЙКА-гийн 3 сайн дурын гишүүн тархинд цус харвасан өвчтөнүүд, тэдгээрийн ар гэрийнхэнд зориулан өдрийн сувилахуйн үйлчилгээг суртчилан таниулах (даралт хэмжих, дахин цус харвахаас урьдчилан сэргийлэх сургалт, сэргээн засах дасгал гэх мэт) үйл ажиллагаа явуулав. Тэдний нэг болох сувилагч Фужикава (2015 оны 3 дахь ээлжийн сайн дурын гишүүн /сувилагч) нь өвчтөнүүд болон тэдгээрийн ар гэрийнхэнд өдрийн сувилахуйн үйлчилгээг үр дүнтэй үргэлжлүүлэхийн тулд эмнэлгийн ажилтнуудад зааж хэвшүүлэх нь чухал гэж үзэн 2017 оны 9 сараас 12 сар хүртэл эмнэлгүүдээр дахин явж зааварчлагаа өгөв. Эмнэлгүүдэд зааварчлагаа өгөхдөө ажилтнуудын дадал хэвшилд голлон анхаарсан бөгөөд зааварчлагааны дараа авсан анкет судалгаанд олон хүн өдрийн сувилахуйн үйлчилгээний ач холбогдолыг “сайтар ойлголоо”, “цаашид үргэлжлүүлэн хийнэ” гэж хариулсан байна. Монгол улсад одоогийн байдлаар Японы өдрийн сувилахуйн үйлчилгээтэй ижил төстэй үйлчилгээ хараахан бий болоогүй байгаа хэдий ч цаашид энэ төрлийн үйлчилгээ нэвтэрч өвчтнүүд болон тэдгээрийн ар гэрийнхний хувьд амьдрахад таатай орчин нөхцөл бүрдэх боломж бүрэн дүүрэн бий.



ЖАЙКА-ийн сургалт төгсөгчдийн холбоо

Сургалт төгсөгчдийн Follow-Up семинар: “Япон улсын татварын өр дуудах төвийн туршлага” сэдэвт семинар болов.



Семинарын явц

12 сарын 7-ны өдөр 2017 оны “Татварын өр дуудах төвийн чававхийг бэхжүүлэх сургалт”-анд оролцогчдын зохион байгуулсан “Япон улсын татварын өр дуудах төвийн туршлага” сэдэвт семинар ТЕГ-т зохион байгуулагдлаа. Уг семинарт Улаанбаатар хотын Сүхбаатар, Хан Уул, Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч 121 хүнээс гадна одоо хэрэгжиж буй “Монголын татварын албаны татвар хураалтын үйл ажиллагаа болон олон улсын татварын асуудлыг боловсронгуй болгох нь II” төслийн мэргэжилтэн оролцож Япон дахь сургалтын явцад сурч мэдсэн Японы туршлагыг танилцуулахын зэрэгцээ Монголын ногдол, өр дуудах төвийн үйл ажиллагаанд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр татварын хэлтсүүдийн цаашдын хамтын ажиллагааг дэмжих арга хэмжээний талаар идэвхитэй санал солилцлоо.

事務所ナショナルスタッフが日本語で執筆！

コラム ～モンゴルの文化・生活事情紹介～ 「シンジル・パーティー」

毎年12月半ばになると、街中はシンジルモード一色になり、会社や学校などではシンジル・パーティー（直訳は新年を祝う会）が開催されます。シンジルは、モンゴル人にとって、一番盛り上がる楽しいイベントです。この時は、皆で楽しいパーティーにするために、会場を華やかに飾り、食事、音楽バンド、出し物、ゲームなどで盛り上がります。また、特に女性はドレスを着て、化粧も服装もばっちり整えた姿で登場します。シンジル・パーティーは、女性にとって、一年で一番着飾る時、と言っても過言ではないでしょう。男性も負けない気持ちで来ますが、女性の華やかさの前ではかないそうにありません。（アンダ所員）



華やかシンジル・パーティー



Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага(ЖАЙКА)

Монгол дахь төлөөлөгчийн газар

Бодь цамхаг, 7 давхар, Сүхбаатарын талбай 3, Улаанбаатар, Монгол улс

(Төв шуудан, шуудангийн хайрцаг: 682, Улаанбаатар 211213, Монгол улс)

Утас:+976-325939, 311329, Факс:+976-310845 Имэйл: mg_oso_rep@jica.go.jp